



136

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Сайд нарын Зөвлөлийн

ТОГТООЛ

1962 оны 6 дугаар
сарын 21-ний өдөр

Дугаар 329

Улаанбаатар
хот

Аймаг, хотын гүйцэтгэх захир- гаадад товчоо байгуулах тухай.

Аймаг, хотын аж ахуй, соёлын зарим асуудал, хөдөлмөрчдийн эрэлт хүсэлтийг хөнгөн шуурхай шийдвэрлэж байх зорилгоор Б Н М А Улсын Сайд нарын Зөвлөлөөс Т О Г Т О О Х нь:

1. Аймаг, хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаадад аймаг, хотын гүйцэтгэх захиргаадын дарга, орлогчид, харилцлагатай нарийн бичгийн дарга, санхүүгийн хэлтсийн дарга нарын бүрэлдэхүүнтэй товчоо байгуулан ажиллуулсугай.

2. Аймаг, хотын ардын депутатуудын хурлын гүйцэтгэх захиргаадын товчоогоор боловсон хүчин, тэтгэвэр тусламж, урамшил, нагнал, тэлээлийн фонд хувиарлах, түр комисс төмилөх, гүйцэтгэх захиргаадынхаа газар, хэлтсийн жил, улирлын ажлын төлөвлөгөөг батлах, ард иргэдээс гаргасан мэдээлэл, өрөгдөл гэмдлын асуудал ба гал түймэр, усны үер, цаг зулын зэрэг гэнэтийн аюул тохиолдвол хүн хүч, уналга, хөсөг тээврийг дайчлан зохион байгуулах зэрэг өдөр нутмын асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3. Товчоогоор хэлэлцсэн асуудалд протокол хөтлөж, гаргах актыг аймаг, хотын гүйцэтгэх захиргаадын тогтоол, захирамж болгон гаргах байхаар тогтоосугай.

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн 4-р орлогч дарга

МОЛ ОМ ЖАМЦ

Б Н М А Улсын Сайд нарын
Зөвлөлийн Б.Н.М.А.У. эрхлэх
гэврийн дарга

БАЦ АРЧ

Хуулбар үнэн. Тогтоол ангийн



G. Adorj

ДАГВАЦОРЖ /